



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/42

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тогтвортой хөгжил-Хичээлийн судалгаа” төслийн хүрээнд Монголын боловсролын хүрээлэнгээс зохион байгуулж байгаа Япон улсад болох сургалт аялалын шалгаруулалтанд төсөл нь тэнцэж Баруун бүсээ төлөөлөн оролцох 6 дугаар сургуулийн физикийн багш Б.Дэлгэрмаагийн сургалтын замын зардалд 1000000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 1 000 000 төгрөг /Нэг сая/-ийг аймгийн Засаг даргын хөрөнгийн болзошгүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ